



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 02 сарын 13 өдөр

Дугаар А/А2

Улаанбаатар хот

Сургалтад оролцуулах, зардал гаргах тухай

Монгол Улсын “Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, тус газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3 дугаар зүйлийн 3.7.1, 3.7.2 дахь хэсэг, Архивын ерөнхий газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн нэхэмжлэлийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Архивийн Ерөнхий газрын сургалтын төлөвлөгөөний дагуу 2018 оны 02 дугаар сарын 27-28-ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдах Баримт бичгийн стандарт, баримт бичгийг зохион бүрдүүлэх арга зүй сургалтад тус газрын Удирдлага, төлөвлөлт, санхүү хамтын ажиллагааны хэлтсийн Бичиг хэрэг, нууц, сургалтын асуудал хариуцсан мэргэжилтэн М.Лхагвасүрэнг оролцуулсугай.

2. М.Лхагвасүрэнгийн сургалтын зардалд зориулж 80.000 /наян мянга/ төгрөгийг тус газрын хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч Д.Отгонбаярт зөвшөөрсүгэй.

ДАРГА



С.ЭНХТҮВШИН